

<https://doi.org/10.69561/mjac.v25i49.3827>

Article | Fasc.2

## Юань улсын судрын 78 дугаар дэвтэр дэх “Ёст малгай”-н төрөлд хийсэн судалгаа

Соёлтын Үүрцайх 

Соёл урлагийн их сургуулийн Дүрслэх урлагийн академи,  
Улаанбаатар, Монгол Улс

Баянзулын Мөнхцэцэг 

Соёл урлагийн их сургуулийн харьяа Соёл, урлаг судлалын хүрээлэн,  
Улаанбаатар, Монгол Улс  
✉ [bamuugii@gmail.com](mailto:bamuugii@gmail.com)

**Хураангуй:** Энэхүү өгүүлэлд Юань улсын судрын 78 дугаар дэвтэр буюу “Тэрэг хувцас нэгдүгээр” дэх ёст малгайн тухай мэдээллүүдийг шүүн нэгтгэж, зарим ойлгомжгүй нэр томъёо, тэдгээрийн утга учрыг тайлбарлав.

“Юань улсын судар”-ыг анх Мин улсын эхэн үед (1368 онд) эртний хятад хэлээр, хятад түшмэлүүд зохиосон ба хэвлэгдсэн цагаасаа хойш өнөөг хүртэл олон удаа хуулбарлан хэвлэгдсэн төдийгүй, зарим тохиолдолд засварлагдсан байдаг тул ойлгомжгүй үг хэллэг элбэг байдаг. Иймээс уг судрыг ашиглахын тулд юуны өмнө тэдгээр ойлгомжгүй үг хэллэг, өгүүлбэрүүдийн утга учрыг судлан тайлах зайлшгүй шаардлагатай болдог.

“Юань улсын судар”-ын 78 дугаар дэвтэрт 63 зүйлийн малгайн нэрс болон тэдгээрийн хэрэглээний талаар үнэ цэнтэй мэдээллүүд бий. Эдгээрийн утга учрыг зөв ойлгож тайлбарлах нь малгайн бодит дүр дүрслэлийг тодруулахад ихээхэн ач холбогдолтой хэдий ч нэг удаагийн өгүүллээр энэ бүгдийг тайлан тайлбарлах боломж хомс тул юуны өмнө “Ёст малгай”-н төрөлд хамаарах малгайнуудын нэрсийн утгыг тайлбарлах зорилго тавьсан болно.

Энэхүү судалгаандаа 1917-1928 онд Монгол Улсын Судар бичгийн хүрээлэнгийн Дандаа Чинсан хэмээн алдаршсан Ч.Дэмчигдоржийн эртний хятад хэлнээс монгол хэлэнд орчуулсан “Юань улсын судар”, 1976 онд хятадын Жүн хуа номын товчооноос хятад хэлээр хэвлэн нийтэлсэн “元史”(Yuan shi) хоёрыг гол эх сурвалж болгон ашиглав. Эдгээр эх сурвалжуудад тэмдэглэгдсэн малгайн нэрстэй холбоотой үл ойлгогдох үг үсэг, өгүүлбэрүүдийг хооронд нь харьцуулахын зэрэгцээ “Юань улсын судрын толь бичиг”(元史词典), “Дундад улсын дээл малгай хувцас чимэглэлийн их толь”(中国衣冠服饰大辞典), “Эртний хятад үсгийн толь бичиг”(古代汉语词典) зэргийг ашиглан эх бичиг судлал, нэр томъёо тайлбарлах аргаар толь бичгүүд дэх тайлбаруудыг ч мөн хооронд нь харьцуулан судалж, утга тайлал хийх эхлэлийг тавив.

Энэ удаа 8 зүйлийн ёст малгайн утгыг тайлбарлаад байна. Цаашид эдгээр үр дүндээ үндэслэн бусад бичгийн эх сурвалжийн мэдээ, дүрслэх урлагийн



дурсгал дахь малгайн дүрслэл, эртний судлалын малтлага судалгаагаар илрүүлсэн археологийн олдвор дурсгалууд, музейн үзмэр зэрэгтэй харьцуулан шинжилж, малгайн хэлбэр дүрс, хэв маягийг тодруулах нь зүйтэй хэмээн үзлээ.

**Түлхүүр үгс:** *Тэнгэрийн хөвүүний ёст малгай, вангийн таван ёст малгай, Хуан тайзын ёст малгай, цуй мянь хэмээх ёст малгай, хатгула ёст малгай*

## Research on the type of “Yost hat” (“Decorum hat”) in Volume 78 of the “Yuán Shǐ” (“The Chronicles of the Yuan Dynasty”)

Uursaikh Soyolt 

Academy of Fine Arts, Mongolian National University of Arts and Culture,  
Ulaanbaatar, Mongolia

Munkhtsetseg Bayanzul  

The Research Institute of Culture and Arts, Mongolian National University  
of Arts and Culture, Ulaanbaatar, Mongolia

✉ bamuugii@gmail.com

**Abstract:** This paper summarizes the information about the “Decorum hats” explains some obscure terms and clarifies their meanings in the “First Article of Attires and Carriages”, Volume 78 of the “Yuán Shǐ” (“The Chronicles of The Yuan Dynasty”).

The “Yuán Shǐ” (“The Chronicles of The Yuan Dynasty”) was originally written in ancient Chinese by Chinese officials during the early Ming Dynasty (1368), and since its publication, they have been reprinted multiple times and edited in some cases, consequently, there are many incomprehensible words and phrases. Therefore, first, it is necessary to study its terminology and decipher the meaning of those obscure words and sentences to use these manuscripts.

Volume 78 of the “Yuán Shǐ” (“The Chronicles of The Yuan Dynasty”) contains valuable information on the 63 types of hats, their names, and uses. The correct understanding and interpretation of these terms are of great importance in clarifying the actual image of hats. There is little opportunity to explain all of them in one paper, although the aim is to explain the meaning of the names of the hats belonging to the “Decorum hat” category.

The “Yuwan ulus un sudur” (“The Chronicles of The Yuan Dynasty) was translated from ancient Chinese into Mongolian by the Mongolian scholar Ch. Demchigdorji, known as “Dandaa Chinsan” of the Institute of Chronicles and Manuscripts between 1917 and 1928, and the “元史” [Yuán Shǐ] published in Chinese in 1976 by the Chinese Junhua Book Bureau, were used as the main source for this paper. In addition to comparing the incomprehensible words and sentences related to the names of hats marked in these sources, “Dictionary of The Yuan Dynasty Chronicles” (元史识识), “Great Mirror of Middle Kingdom Gowns and Hats” (中国衣冠服那大辞典), 古代汉语词典” and “Dictionaries of ancient Chinese characters” were used to study and compare the definitions in the dictionaries with the method of etymological study and interpretation of terms.

This time, the specification and meaning of the 8 types of hats are explained. Based on the above, it is necessary to clarify further the shape and style of the hats by comparing it with information from other written sources, depictions of hats in visual art monuments, artifacts, museum exhibits, and archaeological findings discovered during archaeological excavations.

**Keywords:** *prince's five-ceremonial hat, the heavenly boy's hat, ceremonial hat of Juan stage, traditional hat called tsui miyan, ceremonial hatgula hat.*

## Оршил

Олон улс даяар үндэсний соёлын өв, дурсгалт зүйлсээ судлах, хадгалж хамгаалах, хойч үедээ уламжлуулах, орчин үеийн шаардлагад нийцүүлэн хөгжүүлэх, үндэсний соёлын бүтээлч үйлдвэрлэл, инновацаар дамжуулан улс орны эдийн засгийн тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулах гэх мэт асуудлууд олон нийтийн анхаарлыг татах болжээ. Эдгээрийн дотор үндэсний хувцас томоохон орон зай эзэлж, чухалчлагддаг. Монголчууд үндэсний хувцсаа урлан хийж хэрэглэх явдал өргөн дэлгэр болж, цагаан сарын шинийн нэгэн, улсын баяр наадам, соёлын наадам зэрэг томоохон хэмжээний үйл ажиллагаагаар бүх нийтээрээ монгол хувцсаараа гоёж, цагаан сарын үеэр цэцэрлэг, сургуулийн сурагчид 7 хоногийн турш монгол хувцас өмсдөг заншил тогтож байна. Мөн улсын баяр наадмаар зохион байгуулагддаг “Дээлтэй Монгол” уралдаан тэмцээн улам өргөжин олон улсын шинжтэй болсноос гадна хөдөө орон нутагт ч бас тэмдэглэлт өдрүүдэд үүнтэй ижил төрлийн арга хэмжээ зохиогдож, орон нутгийнхан уран үйлчдээ тодруулж, тэднээрээ бахархаж, монгол эмэгтэйн уран үйлсийг сурталчлан түгээн дэлгэрүүлж байна. Эдгээр үйл ажиллагаа зөвхөн Монгол Улсад төдийгүй нийт монгол туургатан ард түмнүүдийн дунд ч түгэн дэлгэрч буй. Тухайлбал, ӨМӨЗО-нд “Монгол туургатны хувцас, засал” олон улсын наадмыг жил бүр тогтмол зохион байгуулж байна. Мөн цэцэрлэг, сургуулийн багш, сурагчид Даваа гараг бүр монгол хувцсаа өмсдөг, Бээжинд жил бүр “Монгол наадам” зохиогдож, зүг зүгийн монголчууд монгол хувцсаа өмсөж оролцдог зэрэг үйл ажлууд уламжлал болж, газар газрын монголчуудын өнөөгийн амьдралын шинэ хэв маягийн нэг болоод удаж байна. Энэ бүхэн нь монгол хүн гэдгээ мэдэрч бахархаж, ёс уламжлалаа хадгалж, хамгаалж байгаагийн илрэл юм. Эдгээр дэвшилтэт санаачилгууд монгол хувцасны уламжлал болон хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулж байгаа бөгөөд энэ бүх үйл ажиллагааны үр өгөөж, үнэ цэнийг өсгөхийн тулд үндэсний хувцсаа шинжлэх ухаанчаар хандан судлах шаардлагатай. Үүний тулд судалгаа шинжилгээний ажил хийж, үндэслэл сайтай мэдээ, мэдээллийг олон нийтэд түгээх явдал чухал юм. Үүнд, эртний монголчуудын хувцасны талаар бичиж тэмдэглэсэн түүхэн эх сурвалжууд, эртний судлалын олдвор дурсгалууд, дүрслэх урлагийн дурсгалд дүрслэгдэн үлдсэн дүрслэлүүд гээд судалгаа шинжилгээний ач холбогдол өндөртэй эх сурвалж материалууд цөөнгүй байгаагийн нэг нь “Юань ши” буюу “Юань улсын судар” юм. “Юань улсын судар” дахь хувцасны холбогдолтой нэр томьёо, ойлгомжгүй үг хэллэгийн утга учрыг тайлбарлах нь XIII-XIV зууны үеийн монголчуудын хувцасны бодит дүр дүрслэлийг тодруулахад ихээхэн ач холбогдолтой хэдий ч нэг

удаагийн судалгааны өгүүллээр энэ бүгдийг тайлан тайлбарлах боломжгүй юм. Иймээс бид монгол хувцасны бүтэц дэх утга илэрхийлэх шинж, бэлгэдэлт утга санааг нь бодолцон, юуны түрүүнд малгайн тухай тэмдэглэлүүдийг түүвэрлэн авч, төрөлжүүлэн ангилж, утга агуулгыг нь тайлбарлахаас судалгааны ажлаа эхлүүлж буй билээ.

“Юань улсын судар”-ыг анх 1368 онд Мин улсын эхэн үед хятад сударч түшмэлүүд эртний хятад хэлээр найруулан бичсэн (Монгол 2016, 584), (Бира 2017), (Сун 2017), (Идэр 2019, 15) бөгөөд түүнээс хойш 1522, 1596-1606, 1739, 1781, 1824 онуудад ахин дахин хуулбарлан хэвлэгдсэн түүхтэй. Энэ бүхэнд засвар оруулах, орчуулах, шинэ бар сийлж шинээр барлах зэргээр олон дахин хэвлэсэн хэд хэдэн эх бий. Энэ бүхнээс шалтгаалан, энэхүү сударт өнөөгийн бидэнд ойлгомжгүй үг үсэг, найруулга их байдаг. Иймээс бид энэхүү судар дахь үнэ цэнтэй мэдээллүүдийг ойлгож судалгаанд болон бусад олон зорилгоор ашиглахын тулд юуны өмнө ойлгомжгүй нэр томъёо, үг үсгийн утгыг тайлах шаардлагатай болсон.

Биднээс өмнө түүх, эртний судлал (археологи), соёл, хөгжим судлал, хэл шинжлэл хувцасны түүх гэх мэт олон салбар чиглэлийн эрдэмтэн судлаачид “Юань улсын судар” дахь хувцасны тухай зарим тэмдэглэлүүдийг өөрсдийн судалгаандаа ашигласан нь бий (Б.Бадрах 1934-1935; Х.Нямбуу, Монгол хувцасны түүх 2002; Пэрлэйсамбуу 1997; Пэрлэй 2012; С.Соронзонболд 2013; Д.Идэр 2016, 2019; Мин Шин 2013). Эдгээр ажлуудаас Г.Бадрах, Х.Нямбуу, Пэрлэйсамбуу, Пэрлэй нарын бүтээлд нэр томъёо болон бусад үг хэллэгийг хятад эхээс нь орчуулан, эсвэл Дандаа Чинсан Дэмчигдоржийн орчуулсан “Юань улсын судар”-аас ашиглахдаа ойлгомжгүй нэр томъёо, үг хэллэгийн утгыг тайлсан нь ховор, ихэвчлэн өөрсдийн судалж ойлгосноороо тайлбарлан бичсэн байдал ажиглагддаг бол С.Соронзонболд, Д.Идэр, Мин Шин нарын бүтээл орчуулга болон хөрвүүлгийн бүтээл учраас анх зохиогдсон эртний хятад ханз үсэг, уйгуржин монгол бичгээрх үг хэллэгийг эхэд бичсэн хэвээр нь галиглан бичсэн байдаг.

Бидний эх сурвалж болгон ашиглаж буй Дандаа чинсан Дэмчигдоржийн орчуулсан “Юань улсын судар”-ын 71, 78, 79, 80 дугаар дэвтрүүдэд дундад эртний үеийн монгол хувцасны судалгаанд үнэ цэнтэй мэдээ баримтууд нэлээд тэмдэглэгдсэн байдаг. Ёслол хөгжмийн тэмдэглэл<sup>1</sup>-ийн 71 дүгээр дэвтэр буюу **Ёслол хөгжим тавдугаар**<sup>2</sup> нь Хөгжмийн хувцас, Их хөгжмийн захиргаа, Хуримлах хөгжмийн сав, Хөгжмийн анги гэсэн 4 хэсэгтэй ба тэдгээрт хөгжимчид, бүжигчдийн хэрэглэдэг 48 зүйлийн малгайн тухай мэдээлэл байдаг, 78 дугаар дэвтэр нь **Ёст малгай хувцас, Сүүх тэрэг** гэсэн хоёр хэсгээс бүрдэж байгаа ба Ёст малгай хувцасны хэсэгт 62 зүйлийн малгайн тухай, Сүүх тэрэгний хэсэгт

<sup>1</sup> Юань улсын судрын 67, 68, 69, 70, 71 дүгээр дэвтрүүд нь “Ёслол хөгжмийн тэмдэглэл”-д хамаарна.

<sup>2</sup> Дандаа чинсан Дэмчигдоржийн орчуулсан “Юань улсын судар”-т Ёслол хөгжим гуравдугаар гэж байгаа боловч Хятад эх (1976 он)-д Ёслол хөгжим тавдугаар гэж байгаа. Үүнийг нягтлан үзвэл Дандаа чинсан Дэмчигдоржийн орчуулсан “Юань улсын судар”-ын 67, 68, 69, 70 дугаар дэвтрүүд нь Ёслол хөгжим 1, 2, 3, 4 дүгээр гэж дугаарлагдсан байгаа боловч 71-р дэвтрийг дахин 3-р гэж андуурч бичсэн бололтой байна. Иймээс бид Ёслол хөгжим 5-р гэж залруулан бичив.

тэрэгчний 1 малгай, нийт 63 малгайн зүйл тэмдэглэгджээ. 79 дүгээр дэвтэр нь **Ёслолын жагсаал, Тэнгэрийг эрхэмлэх жагсаал, Гадаад жагсаал** гэсэн гурван хэсгээс бүрдэж байгаа ба ёслолын жагсаал хэсэгт 13, тэнгэрийг эрхэмлэх жагсаал хэсэгт 22, гадаад жагсаал хэсэгт 18, нийт 53 малгайн тухай тэмдэглэл багтсан бол 80 дугаар дэвтрийн “Тэрэг хувцас гуравдугаар” нь **Ёслол хамгаалал** гэсэн нэг хэсэгтэй бөгөөд түүний дотор Харшийн дээр хэрэг сахигч, Харшийн доор хэрэг сахигч, Харшийн доор шар манжлагын жагсаал, Харшийн доор хуар жагсаал, Ордны дотор удирдан дагуулах, Дунд ордныг удирдан дагуулах, Гаргах навчит өргөмжлөл дэвшүүлэх<sup>3</sup>нь, Навчит өргөмжлөл хамаарсан түшмэл, жагсаалын зэрэг дэс зэрэг олон жижиг хэсгүүдтэй бөгөөд тэдгээрт 22 малгайн тухай тэмдэглэл байна. Эдгээр дэвтрүүдэд нийт 186 зүйлийн малгайн тухай тэмдэглэл багтсан байна. Тэдгээрт ёслолын малгай, хувцасны зориулалт, өнгө, гоёл чимэглэл, хэрэглэх материал, хийц, өмсөж хэрэглэх дүрэм журмыг хуульчлан заажээ.

Бид эдгээр тэмдэглэлээс малгайн тухай тэмдэглэлийг түүвэрлэн авч төрөлжүүлээд, утга агуулгыг тодруулахын тулд бусад эх сурвалжуудтай харьцуулан судалж эхлээд байна. Энэ удаа 78 дугаар дэвтэрт тэмдэглэгдсэн “Ёст малгайн” төрөл зүйлийн нэр томьёоны утгыг тайлахыг хичээв.

### Судалгааны арга зүй

Юань улсын судар дахь “ёст малгай” хэмээх холбоо үгээр нэрлэгдсэн нэр томьёоны утга болон тухайн нэр томьёогоор илэрхийлэгдэх хувцас өмсгөлийн утга агуулгыг тайлбарлахдаа эх бичиг судлал, нэр томьёо тайлбарлах аргыг ашигласны зэрэгцээ толь бичгүүдийн тайлбаруудыг хооронд нь харьцуулан шинжлэв.

### Судалгааны үр дүн

#### 1. 78 дугаар дэвтэр дэх “ёст малгай”-н тэмдэглэлийн тойм

78 дугаар дэвтэрт тэнгэрийн хөвгүүний ёст малгай, хуан тайзын ёст малгай, вангийн таван ёст малгай, Жөү улсын ёст малгай, цуй мянь хэмээх ёст малгай, хатгула ёст малгай, шюань мянь ёст малгай, ди вангийн ёст малгай зэрэг 8 зүйлийн ёст малгайн талаар дурдагдсан байна. Эдгээр ёст малгайн талаар Юань улсын сударт дараах байдлаар тэмдэглэгдсэн байдаг.

...Ёслолт номд Юй улсын луан тэрэг, Шиа улсын гархит тэрэг, Шан улсын их лү тэрэг, Жөү улсад хүрч ирээд урд үеийг нэмж хорогдуулаад бян шь<sup>4</sup> вангийн таван ёст малгайг захирчээ. Жинь чэ<sup>5</sup> вангийн таван лү тэргийг захирсан тулд сая ёслол янз бүрджүхүй...; ...Жөү улсын ёст малгайн тэгүнү (түүний) янзыг авсан бөгөөд дунддыг олжээ болой хэмээжээ...; ...Шызу (Хубилай хаан) дэлхий дахиныг нэгтгэн хамтатгаад ойр болбоос Алтан улс, Сүн улсаас авч, хол болбоос Хан улс, Тан улсыг дуурайж, Инзунд<sup>6</sup> хүрч ирээд өвгөдийн сүмд биеэр

<sup>3</sup> Навчит өргөмжлөл дэвшүүлэх - Юань улсын үеийн дээд өргөмжлөл олгох нэгэн зүйлийн ёслолын үйл ажиллагаа

<sup>4</sup> Бян шь - Тахилгын ёслолын үед эзэн хааны өмсдөг малгайг тусгайлан хариуцдаг албан тушаалтан (Нийгмийн шинжлэх ухааны хүрээлэн 2020, 28)

<sup>5</sup> Жинь чэ - Эзэн хааны ёслолын тэргийг тусгайлан хариуцдаг албан тушаалтан

<sup>6</sup> Инзун - Юань улсын Содбал “гэгээн” хаан. 1320-1323 онд төр барьж, 1323 онд 20 настайдаа Тэгш, Чинтөмөр нарт алагдсан.

тахиад дахиж төрийн их жагсаал бэлтгэжээ. Өдгөө хянаваас тэр цагт дээр болбоос тэнгэрийн хөвүүний ёст малгай хувцас, хуан тайзын малгай хувцас, тэнгэрийн хөвүүний зүсэн, тэнгэрийн хөвүүний таван лү тэрэг, нурууны сүүх, заант сүүх жич ёслол хамгаалах анги жагсаал доргош зуун түшмэдийн тайх хувцас, бараалах хувцас зуун түшмэдийн зүсэн, түшмэд олон хүмүүнд хүртэл хувцасны өнгө гэрэлтэй янзтай бүхий ба ялгавартай зэрэг дэс бүхий бий амой... гэснээс НТӨ 1046-НТӨ 256 онд оршин тогтнож байсан Жөү улс өмнөх үеийнхээ Ся болон Шан улсын уламжлалд тулгуурлан вангийн таван ёст малгайг шинэчилсэн төдийгүй тэр үед бас ёслол хүндэтгэлийн хувцас хариуцдаг бян шь хэмээх тусгай албан тушаалтантай байжээ гэж ойлгогдож байна. Энд мөн “тэнгэрийн хөвүүний зүсэн”, “зуун түшмэдийн зүсэн” хувцасны өнгөний талаар товч дурдагджээ. Зүсэн хувцас хэмээх нь Юань улсын сударт тэмдэглэснээр малгайнаас гутал хүртэл нэг ижил өнгийн, монгол маягийн хувцас юм.

Энэ бүгдээс үзвэл, Хубилай хаан Дундад орныг эзлэн, төр улсаа эмхлэн, засан тохинуулах бодлого боловсруулахдаа өөрийн байгуулсан их гүрэнд ноёрхолоо тогтоохын тулд монгол төрт ёсны уламжлалыг хадгалахын зэрэгцээ өөрийн шадар зөвлөх Лиү Бинжун, Шүйхэн нартай зөвлөлдөж, эзлэгдсэн олон угсаатан үндэстнийг нэгтгэн захирахад тэдгээр олон үндэстний эртнээс уламжилж ирсэн төрт ёсны уламжлал, хууль цаазад хүндэтгэлтэй хандахын чухлыг баримтлан, тэдний уламжлалаас сонгон авч зохицуулан хэрэглэж, Юань гүрний гэсэн өвөрмөц онцлогтой төрийн тогтолцоог байгуулж, хэрэгжүүлж байсны нэг тод илрэл нь төрийн ёслол хүндэтгэл болон тайлга тахилгын зориулалттай “ёст малгай”, “зүсэн хувцас” гэсэн хоёр төрлийн хувцасны хэв маяг, өнгө зүсийг дүрэмлэн хэрэглэж байснаас харагдаж байна. Энэ тухай Юань улсын судар дахь дараах баримтаас бас мэдэж болно.

...Урьд үеийг байцааваас умард газраас Дундад улсыг олсон ану эрхгүй хятадын хуулийг явуулсан тулд сая хол удаж болжухуй. Тиймийн тул Умард Вэй улс, Ляо улс, Алтан улс жил улирсан ану маш олон бөгөөд бусад чадахгүй ану цөм харилцан залгаж самууран мөхсөн ануг судар дансан дур бичиж тэмдэглэсэн ану тодорхойёо тул байцааваас болмой. Хэрэв улс гэр умард газар дур суусан болбоос үүнийг шүүмжлэх хэрэг үгүй болой. Энэ цагийн засаг энэ бус болвоос яахин зохимой. Хуурай дур явах болбоос тэрэг зохимой, усан дур явах болбоос онгоц зохимой... (Дэмчигдорж 2016). Үүнийг хятад эхтэй нь тулгаж үзвээс ...Эртнийг хянаваас умард оронд хятад хуулийг хэрэглэвээс урт удаан оршин тогтножээ. Хэдийгээр, Умард Вэй улс, Ляо, Алтан улс тогтносон жил нь хамгийн урт ч тэд тэмцэлдэн тулалдаж, байнга хямралдаантай байсныг түүхийн сурвалжид тэмдэглэжээ. Хянан байцааваас ил тод. Улсыг умард газарт байлгавал үүнийг хэлээд хэрэггүй. Өнөөгийн засаг үүнтэй яаж зохих вэ! Хуурай газар тэрэг зохирно, усан дотор завь зохирно. Эс бөгөөс явж чадахгүй... (Лянь 1976, 3719)

Ийнхүү эзлэгдсэн улс үндэстний төрт ёсонд хүндэтгэлтэй хандаж байсны нэг тодорхой жишээ бол тайлга тахилгын ёслолын тогтолцоог бүрдүүлж, түүнд хэрэглэх тэрэг, хувцасны хэв янзыг хуульчлан заахдаа дундад оронд оршин тогтнож байсан эртний Хан, Тан, Сүн, Алтан улсын хэв маягаас авч хэрэглэж байсан явдал юм. Мөн түүнчлэн, Хубилай хааныг залгамжлагчид ч өмнөх үеийнхээ уламжлалыг

суурь болгон өөрийн хаанчлалын үеийн онцлогийг тусгасан хувцасны хэв загварыг тогтоож байсан нь “Инзун” болон “Их эрдэмт”-ийн үед тэрэг хувцсанд хийсэн өөрчлөлтөөс ойлгогдож байна. Үүний тод жишээ бол

...Цуй мянь хэмээх ёст малгай дээш нь гал, уул хоёр бүлэг, хатгула ёст малгай уул нэгэн бүлэг, шюань мянь хэмээх ёст малгайд бүлэггүй...; ...Найман сар жүн шү шэн<sup>7</sup> дур бичгийн утгач, сайдыг хураах тайлганыг эрхэлсэн ёслолын яамны түшмэд хуралдаад өгүүлэлдэн хэлэлцэж, мий шоо жиан<sup>8</sup> дур хадгалсан урд үеийн хуульд заасан ди ван<sup>9</sup>-гийн ёст малгай хувцасны зурагт дэвтрийг дагаж тушаалын түшмэд дур тушааж дүрмийн ёсоор хийжээ...; ...Тан улсын хууль дур хуан тайзын ёст малгай дур цагаан сувд унжуулсан есөн унжлага улаан ширхэг утаснаар хийсэн залаа, хар чихний бөөрөнхий хирсийн хатгуураар удирдмуй... гэсэн тэмдэглэл юм.

Энэ бүхний утгыг тайлахад бараг үг нэг бүрийг тайлбарлах шаардлага гарч байгаа ч эхлээд малгайн нэрсийн утгыг толь бичигт зааснаар авч, Юань улсын судрын тэмдэглэлтэй харьцуулж, улмаар судрын тэмдэглэл дэх түүхэн үйл явдлуудаар мөшгиж тайлбарлах оролдлого хийв.

Юань улсын сударт дээр дурьдсан 8 зүйлийн ёст малгайнаас Тэнгэрийн хөвгүүний ёст малгайн талаар нэлээд нарийн, Хуан тайзын ёст малгайн тухай харьцангуй товч тайлбар бий бөгөөд цуй мянь хэмээх ёст малгай, хатгула ёст малгай, шюань мянь хэмээх ёст малгайн чимэглэлийн талаар маш товч тэмдэглэжээ. Харин бусад ёст малгайн талаар нэрийг нь дурдсан төдий байна. Иймээс эдгээрийг “Юань улсын судрын толь бичиг”, “Дундад улсын дээл малгай хувцас чимэглэлийн их толь”, “Эртний хятад үсгийн толь” зэрэг толь бичгүүдэд хэрхэн тайлбарласан талаар шүүж үзэхээс гадна түүхийн бусад сурвалж, судалгааны материалуудаас сурвалжлан тайлбарлав.

## 2. “Ёст малгай” хэмээх нэрийн утгын тухайд

78 дугаар дэвтэрт нэлээд хэдэн зүйлийн “Ёст малгай” тэмдэглэгдсэн байгаа учраас юуны өмнө “Ёст малгай” хэмээх холбоо үгээр нэрлэгдсэн нэр томъёоны ерөнхий утгын талаар тайлбарлах хэрэгтэй болно. Энэ талаар дээр дурьдсан толь бичгүүд болон түүхийн бусад сурвалж, судалгааны материалуудаас судалж үзвэл дараах байдалтай байна.

“Юань улсын судрын толь бичиг”-т 衮冕 [gun mian]: 衮衣和冠冕. 为帝王及士大夫的礼服和礼貌 (Шүсэн 2002, 1206) гэж тайлбарлажээ. Үүнийг монголчилбол, Ёст малгай: Ёст хувцас ба Ёст малгай, Эзэн хаан болон бичгийн түшмэлийн ёслолын хувцас ба малгай гэжээ.

“Дундад улсын дээл малгай хувцас чимэглэлийн их толь бичиг”-т “[衮冕] (gun mian) гэдгийг衮亦作 “衮”(gun) 帝王祭祀时所穿的绣有龙形的礼服. 亦用作上公礼服, 唯纹饰有别. “六冕”之一. 由冕冠, 冕服, 蔽膝, 大带, 珮缓等组成. 天子冕冠用十二旒, 每旒用珠玉十二颗. (Жөү Шюн 1996, 133) гэж тайлбарлажээ. Үүнийг монголчилбол, [Ёст малгай]: 衮(gun)-г бас “衮”(gun) гэж бичдэг. Эзэн хаан тахил өргөх

<sup>7</sup> жүн шү шэн - Хятадын эртний засаг захиргааны нууц байгууллага

<sup>8</sup> мий шоо жиань яам - Хятадын эртний засгийн ордны улсын ном хадгалах болон эмхэлж найруулдаг яам эсвэл, тушаалын нэр

<sup>9</sup> Ди Ван- Эзэнт улсын хамгийн том ноёрхогч (Шинхуа толь бичигт тайлбарлажээ)

үедээ өмсдөг луун дүрст хатгамалтай ёслолын хувцсыг хэлнэ. Мөн албаны ёслолын хувцас болгон ашигладаг, хээ угалз нь өөр. Зургаан ёст малгай хувцасны нэг. Ёслолын малгай,<sup>10</sup> ёслолын хувцас,<sup>11</sup> өвдгөвч,<sup>12</sup> их бүс,<sup>13</sup> хаш чимэгт тууз<sup>14</sup> гэх мэтээс бүрдэнэ. Тэнгэрийн хүүгийн ёслолын малгайд арван хоёр хаш чулуун унжлага хэрэглэдэг бөгөөд унжлага бүрт арван хоёр сувдан хаш чулууг ашигладаг гэж тайлбарлажээ.

“Эртний хятад үсгийн толь”-д [袞冕] (gun mian): “古代帝王或公候的礼服和礼帽 (Эртний 1999, 2087). Монголчилбол, [Ёст малгай]: Эртний Эзэн хаан, хүү ноёны ёслолын хувцас болон ёслолын малгай гэж товч тайлбарласан байна.

Эдгээр 3 толь бичгийн тайлбараас “Ёст малгай” хэмээх нэр томъёо нь 1-рт, зөвхөн малгайг зааж буй бус тахил өргөх зан үйл болон албаны ёслолд өмсдөг хувцсыг зааж байна. 2-рт, ёст малгайг эзэн хаад болон тэдний хөвгүүд буюу хан хүү нараас гадна бичгийн түшмэлүүд өмсдөг гэж ойлгогдож байна. “Дундад улсын дээл малгай хувцас чимэглэлийн их толь бичиг”-т ёст малгайн иж бүрдлийг ёслолын малгай, ёслолын хувцас, өвдгөвч, их бүс, хаш чимэгт тууз зэргээс бүрдэнэ гээд, тэнгэрийн хүү буюу эзэн хааны ёслолын малгай нь арван хоёр хаш чулуун унжлагатай бөгөөд унжлага бүр арван хоёр сувдан хаш чулуугаар чимэглэсэн байдаг гэж дэлгэрүүлжээ.

Монголын дундад эртний үеийн хувцасны түүх, соёлын судалгааны бүтээлүүд (Бадрах 1934-1935; Пэрлэйсамбуу 1997, 709; Нямбуу, Монгол хувцасны түүх 2002, 36-42; Нямбуу 1992, 3-54; Инжинаш 2009, 336)-ээс үзвэл, хаадыг хаан ширээнээ залах, тэнгэрийн тайлга хийх гэх мэт төрийн ёслол хүндэтгэлийн зан үйлийн үед ёст малгай хэрэглэж ирсэн уламжлал байсан нь ойлгогддог. Энэхүү “Ёст малгай” хэмээх нэрийг судлаачид ёст малгай, ёслог малгай, ёслолын малгай гэх зэргээр хэд хэдэн янзаар орчуулан нэрлэж, өөрсдийн судалгааны бүтээлдээ ашиглажээ. Харин “Монгол хэлний их тайлбар толь”-д ёст малгай гэдэг үгийг (хуучирсан) хэмээн тодотгоод, ихэс дээдэст бараалхахад өмсөх тусгай малгай гэж тайлбарласан байгаа нь 1-рт, өнөө үед хэрэглэгдэхээ больсон, эртний эд болохыг, 2-рт, хэрэглэх хүрээ, шаардлага нь ч өнөө цагт өөрчлөгдсөн зэрэгтэй холбоотойгоор тайлбар нь өөрчлөгдсөн байх бололцоотой юм. Нөгөөтэйгүүр, зөвхөн малгай гэдэг утгаар нь хандаж тайлбарласан тал ажиглагдаж байна. Бидний хувьд Юань улсын сударт оноон нэрлэсэнээр нь “Ёст малгай” хэмээн нэрлэв.

### 3. 78 дугаар дэвтэрт тэмдэглэгдсэн “ёст малгай”-н төрлүүд

**1. Тэнгэрийн хөвгүүний ёст малгай:** 78 дугаар дэвтрийн “Ёст малгай хувцас” бүлгийн Тэнгэрийн хөвүүний ёст малгай, хувцас гэсэн зүйл байгаа ба түүний Ёст малгайн хууль гэсэн хэсэгт тэнгэрийн хөвгүүн буюу эзэн хааны ёст малгайн тухай дэлгэрэнгүй тайлбарлан бичжээ. Үүнд:

...Бараан хиаван<sup>15</sup>-гаар дээр бүтээснийг бүрхүүл хэмээмүй. Хар гадар улаан

<sup>10</sup> Ёслолын малгай 冕冠 (mian guan)

<sup>11</sup> Ёслолын хувцас 冕服 (mian fu)

<sup>12</sup> Өвдөг халхавч 蔽膝 (bi xi)

<sup>13</sup> Их бүс 大带 (da dai)

<sup>14</sup> Хаш чимэг тууз 珮绶 (pei shou)

<sup>15</sup> Хиябан(Хиаван) - Монгол олсны ширхэгээр нэхсэнийг нь хиябан хэмээмүй (Цэгээн хиябан, өнгөт хиябан зэрэг төрлүүд бий) (Сумьяабаатар 2006, 104).



дотор, бүрхүүлийн эргэн тойронд үүлэн луу, малгайн амыг дагаж сувд тойруулжухуй, бүрхүүлийн өмнө хойно тус бүр арван хоёр цацгийг сувдаар хийжухуй, бүрхүүлийн зүүн баруун дур бөөрөнхий хоёрыг хар торгоор уяжухуй. Хас бий амой. Бөөрөнхийн өнгө шар, сувд хэлхэжухуй. Малгайг тойрч сувд, үүлэн лууны тороор зангидаад цүй лиу<sup>16</sup>-гаар нэвтрүүлийн сувдаар найруулжухуй (зохицуулна). Бүрхүүлийн дээр хөндлөн тэнгэрийн оёдлын бүс нэг, зүүн баруун этгээдээр газарт хүрмүй, сувд үүрэн тороор цүй лиуг уяжухуй, улаан ширхэгийн цацаг хоёрыг унжлага болгож цүй лиу дур сувдан хагтуураар найруулан малгайг хасаар хөндлөн нэвтэлжухуй...

гэж Эзэн хааны тайлганд хэрэглэх ёст малгайн гадар болон дотор, цацгийн өнгө, материал, чимэглэл, дүрслэл, унжлага тэдгээрийн тоо, хэмжээ, байрлал, хэрэглэх арга зэргийг нэг бүрчлэн тоочжээ.

...Их эрдэмт<sup>17</sup>-ийн арван нэгдүгээр оны есөн сард суралцсан түшмэл Тан улсын хуулийг хэлэлцсэн ану тэнгэрийн хөвгүүний ёст малгай дур цагаан сувд арван хоёрыг унжуулмой, унжлагыг цацгаар залаа хиймүй, өнгө ину тэгүнү цацгийн мэт, бөөрөнхий чихний унжлага хас хатгуураар удирджухуй. Бараан дээл харавтар хормогч хэмээжухуй. Бүгд арван хоёр бүлэг, найман бүлэг дээл дур бий амой, наран, саран, одон гариг, уул, луу, алаг гургууль, гал, зун и<sup>18</sup>, дөрвөн бүлэг хормогч дур бий амой. Зоу<sup>19</sup>, Фэнь ми<sup>20</sup>, фү<sup>21</sup>, фү<sup>22</sup>. Давхар захд мандах луутай, цөм нэхмэллэж бүтээжээ. Луун бүлгээс дорогш бүлэг бүр дур нэгэн мөр, мөр бүр дур арван хоёр. Цагаан хиаван жун шань, фүний зах бараан давхарласан хормогч, фү дур луу, уул, гал гураван бүлгийг нэммүй. Цуй мянь хэмээх ёст малгай дээш ану гал, уул хоёр бүлэг, хатгула ёст малгай уул нэгэн бүлэг, шюань мянь хэмээх ёст малгай дур бүлэггүй. Арьсан бүс, их бүс, хаш зүүдэл, цацаг оймс ану дээрлүгээ адил. Шаавар дур алтан хээ нэммүй. Сүм дүр тахих ба сүм дүр бараалах жич улсаас дээд жанжныг дайлахаар илгээгээд эргэхүй дүр ба, суурин дур сууваас уг хувцас нэммүй. Хуанхөү авах ба цагаалах өдөр бараалахыг хүлээн авах ба, жич сөхөвч гэр дүр халах ба навчит өргөмжлөлөөр ван гүн өргөмжлөх болвоос өмсмүй. Бас Сүн улсын хууль дур тэнгэрийн хөвгүүний хувцсан дур бүхий, ёст малгай агуу ану тохой хоёр ямх, урт ану дөрвөн ямх, өмнө хойно арван хоёр унжлага хоёр бөөрөнхий жич хэлхсэн сувд, бас сувдан унжлага арван хоёр бий амой, хөх гарди зуужухуй, сувдан унжлаганы гадуур бий амой, ёст малгайн хавтгай мод, лууны хайрсыг хэрэглэж хэмэрлиг<sup>23</sup>-ийн гадар хас шигтгэж, долоон одон болгож, хажуу дур

<sup>16</sup> Цуй лиу- оюу ба номин ногоон өнгөтэй уд мод

<sup>17</sup> Их эрдэмт- Их Юань улсын Төмөр хааны төр барьж байсан үеийн оны цол (1297-1307он) (Идэр 2019, 181)

<sup>18</sup> Зун И- Эртний Хятадын хааны тахил өргөх ёслолын хувцасны хатгамал хээ чимэглэлийн нэр. Тэрхүү хээ чимэглэл нь бар, тусгай зүйлийн сармагчин дүрсэлсэн байх нь элбэг.

<sup>19</sup> Зоу - замаг

<sup>20</sup> Фэнь ми - тутарга

<sup>21</sup> Фү - цагаан иртэй хар сүх

<sup>22</sup> Фү - хөх, хар алагласан хос нуман үсгэн хээ

<sup>23</sup> Хэмэрлиг - Зүйл бүр өнгийн ёнхороор бага шиг ар болгож нэхсэнийг нь хэмэрлиг хэмээхүй (Сумьяабаатар 2006, 101).

хавтгай хув оруулан хирс хорин дөрөв, эргэн тойронд алтан ширхэгийн тор болон сувд, тана элдэв эрдэнэ шигтгэжүхүй, хас дур улаан үүл, цагаан тогоруу нэммүй, хэмэрлэг дотортой дөрвөн тулгуур дур долоон эрдэнээр хээлээд улаан линсээ<sup>24</sup> дотортой, алтан хээ хас хатгуураар улаан ширхэгийн цацаг бүсийг удирдмой, үүнийг бас “пинтиян гуань малгай” хэмээмүй... гэсэн байна.

Энэхүү тэмдэглэлд Хубилай хааны орыг залган хаан ширээнд суусан Төмөрийн төр барьсан 12 жилийн сүүлчийн онд буюу Их эрдэмтийн арван нэгдүгээр онд (1307 он) түшмэлүүд Тан болон Сүнгийн хувцасны хувцасны хуулийг судлан хэлэлцэж, хааны ёслолын малгай хувцсанд нэмэлт өөрчлөлт оруулсан байна. Мөн Төмөр хаанаас хойш Содбал хааны төр барьсан сүүлийн жилд ч ёслолын хувцасны хуульд шинэчлэл хийгджээ.

**2. Ди вангийн ёст малгай:** Судалгаанд ашиглаж байгаа “Юань улсын судар”-ын хятад, монгол эх болон толь бичгүүдэд Ди вангийн ёст малгайг тайлбарласан зүйл үгүй боловч Шинхуа толь бичигт зөвхөн Ди ван [帝王 di wang] Эзэнт улсын хамгийн том ноёрхогч (Хятадын Нийгмийн шинжлэх ухаан 1958, 287) хэмээн тайлбарлажээ. Үүнд үндэслэн үзвэл, тэнгэрийн хөвгүүн буюу эзэн хааны ёст малгай гэсэн утгатай байх магадтай байна.

### **3. Хуан тайзын ёст малгай:**

“...тайлганыг эрхэлсэн яамны хураамжилсан ёслол дур үзвээс жь юаны<sup>25</sup> арван хоёрдугаар он дур суралцсан түшмэл ёст малгайн хуулийг туурвисан ану цагаан сувд есөн унжлага, улаан ширхэг утаснаар залаа болгожухуй. Хар чихний бөөрөнхий, хирсийн хатгуураар удирдмой...” гэжээ.

...Их эрдэмтийн арван нэгдүгээр оны есөн сард урд үеийн хууль ёсоор туурвиж Тан улсын хууль дур Хуан тайзын ёст малгай дур цагаан сувд унжуулсан 9 унжлага, улаан ширхэг утаснаар хийсэн залаа, хар чихний бөөрөнхий, хирсийн хатгуураар удирдмой...

...Сүн улсын хууль, Хуан тайзын ёст малгай, цагаан сувдын 9 унжлага унжуулмой, улаан ширхэгээр хийсэн залаа, хар чихний бөөрөнхий, хирсийн хатгуураар удирдмой... гэжээ.

Дээрх тэмдэглэлийн Хуан тайзын ёст малгайн талаар бичсэн тэмдэглэлээс үзвэл, Хубилай хаан 1264-1297 онд Их Юань улсын төрийн эрхийг барьж байсан үед хуульчлан тогтоосон Хуан тайзын ёст малгайн хэв маяг Төмөр хааны төр барьж байсан үе (1297-1307 он)-д хэвээрээ хадгалагджээ.

**4. Таван ёст малгай:** Юань Улсын судрын 78 дугаар дэвтрийн “Тэрэг хувцасны тэмдэглэл”-д ...Ёслолт ном<sup>26</sup> вангийн таван ёст малгайг захирчухуй... гэсэн тэмдэглэл байна. Энд тэмдэглэгдсэн “вангийн таван ёст малгай” хэмээхийн утга бидний хэрэглэж буй 3 төрлийн толь бичигт байхгүй, харин “Дундад улсын дээл малгай хувцас чимэглэлийн их толь”-д “Таван ёст малгай” гэсэн нэр байгаа тул энэ талаар авч үзэв.

<sup>24</sup> Линсээ - Нарийн нягт нэхээстэй, гөлгөр гадаргуутай хив торгоны хятад нэр

<sup>25</sup> жь юань (мон. Их бүтээлт) - Хубилай хаан 1264-1297 онд Их Юань улсын төрийн эрхийг барьж байсан үеийн оны цол (Идэр 2019, 181)

<sup>26</sup> Ёслолт ном - Хятад улсын хамгийн эртний хаант төрийн үйл хэргийн түүхэн явдлыг тэмдэглэсэн “Засагт ном” хэмээх түүхийн эмхэтгэлд багтсан бичиг

[五冕] (wu mian): 帝王祭祀, 朝会时用的五种冕服。指衮冕, 髻冕, 毳冕, 希冕、玄冕。实际上冕服有六种, 因大裘之冕无旒, 故不在此数。Монголчилбол, [Таван ёст малгай]: “Хаан эзний тахилга, төрийн хуралд хэрэглэдэг гүнх мяань, жи мяань, цуй мяань, чь мяань, шюань мяань гэсэн таван зүйлийн ёслолын хувцсыг заана”. Үнэндээ ёслолын хувцас нь зургаан зүйл байна, их дээлийн титэмд унжлага байхгүй, иймээс энд багтахгүй гэжээ. Тайлбараас үзвэл энэ 5 ёст малгай зөвхөн хаан эзэнд хамааралтай гэсэн утга гарч байна. Энд буй цуй мяань, чь мяань, шюань мяань зэрэг 3 малгайн нэрс 78 дугаар дэвтэрт тус бүр нэг нэг тэмдэглэгджээ. Эдгээрийн утгыг зөвхөн “Дундад улсын дээл малгай хувцас чимэглэлийн их толь”-д дараах товч тайлбар байна.

**5. Цуй мянь ёст малгай:** [毳冕] (cui mian): <省称“毳”.帝王及诸臣的礼服。“六冕”之一。Монголчилбол, [Цуй мяань ёст малгай]: товчоор <毳> гэж нэрлэнэ. Эзэн хаан болон олон түшмэлийн ёслолын хувцас “Зургаан ёст малгай”-н нэг” гэсэн товч тайлбар байгаа ба Юань улсын судрын 78 дугаар дэвтрийн ёст малгайн хуулийн тухай хэсэгт ...Цуй мянь хэмээх ёст малгай дээш ану гал, уул хоёр бүлэг... хэмээсэн нь тэрхүү малгайн чимэглэлийн тоо ширхэгийн тухай заасан гэж үзэхээр байна.

**6. Хатгула ёст малгай:** [絺冕] (chi mian) чь мянь: “[希(xi) 冕] 亦作“絺冕”“绣冕”。帝王及公侯的礼服。祭祀五谷之神及五色之帝时服之。“六冕”之一。由冕冠, 冕服, 蔽膝, 大带及佩绶等组成。Монголчилбол, [Хатгула ёст малгай]: [希(xi) 冕] Бас “絺冕”, “绣冕” гэж нэрлэдэг. Эзэн хаан, түшмэл ноёны ёслолын хувцас. Үр тарианы тахилын үед эзэн хааны өмсдөг 5 зүйлийн ёст хувцас. “Зургаан ёст малгай”-н нэг. Ёслолын малгай, ёслолын хувцас, өвдөгний халхавч, том бүс, туузаас бүрдэнэ” гэжээ.

**7. Шюань мянь ёст малгай:** [玄冕](xuan mian): 亦作“元冕”。又称“裨(bi)冕”, “卑冕”。帝主及诸臣的礼服。帝王祭群小祀及大夫助祭时所服。“六冕”之一。玄衣纁裳, 衣无纹章, 下其绣黻一章。其制出现于商周。Монголчилбол, [Шюань мянь ёст малгай]: Мөн “元冕” гэж нэрлэдэг. Бас “裨(bi) 冕”, “卑bei冕” гэж нэрлэх нь ч бий. Эзэн хаан болон түүний олон түшмэлийн ёслолын хувцас. Эзэн хаан болон олон түшмэлийн тахилын хувцас. “Зургаан ёст малгай”-н нэг. [玄冕] (xuan mian) 诸冕统称。因冕版上部覆以玄布, 故名。Монголчилбол, [Шюань мянь ёст малгай]: “Олон төрлийн ёслолын малгайн нийтлэг нэрийдэл” гэж тайлбарлажээ.

**8. Жөү улсын ёст малгай:** Жөү улсын ёст малгай:周冕[zhou mian] Жоу улсын тахилын хувцсанд хэрэглэх малгай. Күнзийн “Шүүмжлэл өгүүлэл” (论语, 卫灵公)-д “Ар тал нь өндөр, урд нь намхан, урд болон хойд тал нь унжлагатай.” Күнз зан үйлийн дүрмээ дэлгэрүүлэхдээ “Жөү улсын ёст малгай хувцас өмсөхийг” сурталчилсан. Жу Си<sup>27</sup> “Жөү улсын ёст малгай”-г бяцхан зүйл бөгөөд энэ нь бүх биед нэмэгддэг (хүний биеийн хамгийн дээр байрладаг гэсэн утга илэрхийлнэ), тиймээс энэ нь үзэсгэлэнт боловч тансаглал биш, үнэтэй боловч бүрэлгэн биш гэж үздэг. Багш соёлыг эрхэмлэвээс зөв хэмээн үзсэн болой (Жан 2010) гэснээс үзвэл, Жөү улсын ёст малгай хэмээх нь хамгийн эртний уламжлалтай, бэлгэдэлт утга агуулга гүн болох нь Күнз уг малгайг хэрхэн үнэлж буйгаас ойлгогдож байгаагийн зэрэгцээ ...Жөү улсад хүрч ирээд урд үеийг нэмж хорогдуулаад бян шь вангийн

<sup>27</sup> Жу Си - 朱熹(1130 年 -1200 年- 1132-1200 онд амьдарч байсан Өмнөд Сүн улсын философич

таван ёст малгайг захиржээ... гэснээс Жөү улсын ёст малгай болон бусад 4 зүйлийн ёст малгайг тусгайлан хариуцдаг бян шь буюу тахилгын ёслолын үед эзэн хааны өмсдөг малгайг хариуцдаг албан тушаалтантай байжээ.

### Хэлэлцүүлэг

Судалгаанд ашигласан толь бичгүүдийн тайлбараас үзвэл, хаад, хааны хөвгүүд болон хаан төрийн түшмэдийн төр ёсны тахил өргөх ёслолд өмсдөг малгай, дээл хувцас, тэдгээрийн чимэг зүүсгэлийг хуулиар тогтоон, нийтэд нь “ёст малгай” хэмээн нэрлэдэг байжээ.

“Ёст малгай” хэмээх нэр томьёо нь 1-рт, зөвхөн малгайг зааж буй бус тахил өргөх зан үйл болон албаны ёслолд өмсдөг хувцсыг зааж байна. 2-рт, ёст малгайг эзэн хаад болон тэдний хөвгүүд буюу хан хүү нараас гадна бичгийн түшмэлүүд өмсдөг гэж ойлгогдож байна. Мөн “Дундад улсын дээл малгай хувцас чимэглэлийн их толь бичиг”-т ёст малгайн иж бүрдлийг ёслолын малгай, ёслолын хувцас, өвдгөвч, их бүс, хаш чимэгт тууз зэргээс бүрдэнэ гээд, тэнгэрийн хүү буюу эзэн хааны ёслолын малгай нь арван хоёр хаш чулуун унжлагатай бөгөөд унжлага бүр арван хоёр сувдан хаш чулуугаар чимэглэсэн байдаг гэж дэлгэрүүлснээс тэдний ёст малгайн бусдаас ялгарах онцлог нь харагдаж байна.

### Дүгнэлт

“Юань улсын судар”-ын 78 дугаар дэвтэр буюу “тэрэг хувцасны тэмдэглэл” дэх ёст малгайн утгыг тайлснаар тухайн үеийн эзэн хаад, Хуан тайз нар буюу хааны хөвгүүд, суралцсан түшмэлүүдийн тахил өргөл, төрийн ёслолд өмсөж зүүдэг малгай, хувцасны төрөл зүйл, тэдгээрийн бүтэц, заримынх нь хэмжээ харьцаа, өнгө будаг, хэрэглэх материалын тухай нарийн мэдээллийг тодрууллаа.

Сударт тэмдэглэгдсэн 8 зүйлийн ёст малгайн “Тэнгэрийн хөвгүүний ёст малгай” нь зөвхөн эзэн хаанд хамаатай, харин “Вангийн таван ёст малгай”-г “Хаан эзний тахилга, төрийн хуралд хэрэглэдэг *гунь мянь, жи мянь, цуй мянь, чь мянь, шюань мянь* гэсэн таван зүйлийн ёслолын хувцсыг заана” гэсэн байгаа боловч эдгээрээс *цуй мянь, шюань мянь* гэсэн хоёр зүйл нь эзэн хаан болон олон түшмэлийн ёслолын малгай, хувцсыг заана гэсэн тайлбартай давхцаж байна. Харин Хуан тайзын ёст малгай нь “Тэнгэрийн хөвгүүний ёст малгай”-аас цөөн чимэг зүүсгэлтэйгээрээ ялгагдах ажээ.

Хатгула ёст малгай нь эзэн хаан болон түшмэл ноёд үр тарианы тахилгын үед өмсдөг уулаар чимсэн ёслолын малгай, ёслолын хувцас, өвдгөвч, том бүс, туузаас бүрдсэн хувцас ажээ.

Ди вангийн ёст малгай: ...ди вангийн ёст малгай хувцасны зурагт дэвтрийг дагаж тушаалын түшмэд дур тушааж дүрмийн ёсоор хийжээ... гэснээс үзвэл эртний хаадын ёст малгай хувцасны нийтлэг нэр буюу вангийн таван ёст малгай, цуй мянь хэмээх ёст малгай, хатгула ёст малгай, шюань мянь ёст малгай, Жөү улсын ёст малгай бүгдийг нийтэд нь хамруулсан нэр бололтой.

Юань улсын эзэн хааныг тэнгэр болон газар тариалангийн тахилга, өвгөдийн сүмийн тахилга, навчит өргөмжлөл соёрхох зэрэг төрийн ёслолын үйл ажиллагааны үед өмсөх ёслолын малгай, дээл хувцасны дүрмийг төрийн суралцсан түшмэлүүд хэлэлцэн хуульчлан тогтоодог байсан байна. Ингэхдээ, Эзэн хааны эзэмшилд хамаарах бусад үндэстэн, угсаатнуудын уламжлалт ёст хувцасны хууль дүрмийг судлан хэлэлцэж тухайн төрийн эзэн хааны ёст малгайн хууль дүрмийг боловсруулдаг байжээ.

Энэ удаагийн судалгаагаар гаргаж авсан тайлбараа 78 дугаар дэвтэрт буй ёст малгайн тухай хууль болон түүхэн сударт тэмдэглэгдсэн ёслолын хувцастай холбоотой бусад мэдээлэл, дүрслэх урлагийн дурсгал дахь дүрслэл, малтлага судалгаагаар илрүүлсэн археологийн олдвор дурсгалууд, музейн үзмэр зэрэгтэй харьцуулан шинжилж, Юань гүрний үеийн хаад, ноёдын ёслолын хувцасны хэлбэр маягийг үнэн зөв тодруулах боломж нэмэгдлээ.

Энэ мэтчилэн “Юань улсын судар”-т буй ойлгомжгүй нэр томъёо, үг үсгийн утгыг тайлж ойлгох нь цаг хугацаа, хүч хөдөлмөр ихээр шаардаж байгаа ч үнэн зөв ойлголт, мэдээ, мэдээлэлтэй болохын тулд улам бүр хичээн ажиллах зайлшгүй шаардлага байна.

Эцэст нь дүгнэж үзвэл, Монголын эзэнт их гүрний үргэлжлэл болох Их Юань гүрэн нь 1-рт, монголын өндөрлөгт мандан бадарч, буурч доройтож байсан Хүннү, Сяньби, Нирун, Хятан зэрэг монгол угсаатны төр улсуудын түүхээр нөхцөлдөж боловсорсон төрт ёс, төрийн ёслол хүндэтгэлийн уламжлалд суурилсан; 2-рт, өөрсдийн байгуулсан эзэнт их гүрний бүрэлдэхүүнд багтсан олон үндэстэн угсаатны уламжлалаас сонгон авсан төрийн ёслол хүндэтгэлийн хувцасны хэв маягийг хуульчлан тогтоож, түүхэн цаг үеийн онцлогт нийцүүлсэн ёслол, хүндэтгэлийн хувцасны хэв маягийг хөгжүүлэн хэрэглэж байжээ.

### Ашигласан материалын жагсаалт

Бадрах, Г. 1934-1935. *Чингисээс дээд үеийн монгол хувцасны өгүүлбэр*. Улаанбаатар. /Гар бичмэл/

Бира, Шагдар. 2017. “Хятад дахь Монгол хаадын ордны түүх бичлэг: Yuan-Shih Монголын түүх бичлэгийн түүхэн сурвалж болох нь.” *Эрдмийн бүтээлийн эмхэтгэл Х-Д*, Шагдар Бира-ээр, 65-72. Улаанбаатар: “Соёмбо принтинг” ХХК.

Дэмчигдорж, Ч. 2016. *Юань Улсын судар*. Улаанбаатар: Соёмбо принтинг.

Жөү Шюн Жөү, Чүн Мин Гао. 1996. *Дундад улсын дээл малгай хувцас чимэглэлийн их толь*. Шанхай: Шанхайн толь бичиг номын хэвлэлийн хороо.

Идэр, Д., Тайвансүрэн, С. 2019. *Монголын их хатад*. Улаанбаатар: Соёмбо принтинг ХХК.

Идэр, Д., Чинзориг, Б., Содбилэг, Ч. 2019. *Их Юань хэмээх Их Монгол Улс*. Улаанбаатар: Степпе паблишинг.

- Идэр, Даваацэрэн. 2016. *Их Юань улсын хатад*. Улаанбаатар: Мөнхийн үсэг ХХК.
- Инжинаш, В. 2009. *Хөх судар. II дэвтэр*. Хөрвүүлсэн Чоймаа, Ш., Баярсайхан, М. Улаанбаатар: Мөнхийн үсэг.
- Лянь, Сун. 1976. *Юань Улсын судар: 158 дугаар дэвтэр*. Бээжин: Жунхуа номын товчоон.
- Мин Шин, Бо. 2013. *Дундад улсын умардын эртний үеийн цөөн тоот үндэсний хувцас заслын судлал, Юань Мин эвэхмэл*. Шанхай: Дүн Хуа их сургуулын хэвлэлийн хороо.
- Монгол, сурвалж бичгийн өв. 2016. *Юань улсын судар*. Орч. Дэмчигдорж, Ч. Улаанбаатар: Соёмбо принтинг ХХК.
- Нийгмийн шинжлэх ухааны хүрээлэн, Хэл шинжлэлийн институт, Толь бичиг найруулах хэлтэс. 2020. *Шинхуа толь бичиг: 12-р хэвлэл*. Бээжин: Худалдаа явдлын ном хэвлэлийн ордон.
- Нямбуу, Ханд. 2002. *Монгол хувцасны түүх*. Улаанбаатар: Адмон ХХК.
- Нямбуу, Ханд. 1992. *Хүндлэхийн дээд хөх Монголын төрийн ёслол, Чингисийн тахилга*. Өндөр хаан: Алтан үсэг ББХК.
- Пэрлэй, Б. 2012. *Монголчуудын эдийн соёл*. Хөх хот: Өвөр монголын ардын хэвлэлийн хороо.
- Пэрлэйсамбуу. 1997. *Монгол үндэстний хувцас заслын соёл*. Шэн Ян: Ляонины үндэстний хэвлэлийн хороо.
- Соронзонболд, С. 2013. *Монгол хөгжим*. Улаанбаатар: ОБ Капитал Пресс.
- Сумьяабаатар, М. 2006. *Гучинзургаат тайлбар толь. Хорингурав дугаар дэвтэр*. Улаанбаатар: Монголын Шинжлэх Ухааны Академи, Хэл зохиолын хүрээлэн.
- Сун, Лиань. 2017. *Юань улсын судар*. Орч. Идэр, Д. Улаанбаатар: Соёмбо принтинг ХХК.
- Хятадын Нийгмийн шинжлэх ухаан, хэл шинжлэлийн хүрээлэн. 1958. *Орчин үеийн хятад хэлний Шинхуа толь бичиг: VII хэвлэл*. Бээжин: Худалдааны явдлын хэвлэлийн газар.
- Шанхайн толь бичгийн нийгэмлэг. 2010. *Күнзийн нэвтэрхий толь*. ер. ред. Жан, Дайнянь (张岱年主编. 孔子百科辞典、上海: 上海辞书社, 2010.). Шанхай: Шанхайн толь бичгийн нийгэмлэг.
- Шүсэнь, Чийү. 2002. *Юань Улсын судрын толь бичиг*. Бээжин: Шандүн мужийн сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо.
- Эртний хятад үгсийн толь бичиг эмхтгэдэг анги. 1999. *Эртний хятад үгсийн толь бичиг*. Бээжин: Худалдаа явдлын хэвлэлийн газар.